

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ГАНБОЛДЫН СОНОМЦЭВЭЭНИЙ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах							
1.	Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр	-	1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна. 2. Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар бууруулсан байна. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт,	Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд: 1. БЦТ-өөс аж ахуй нэгж, иргэн, мэдүүлэгч байгууллагыг эрсдэлийн зөвшөөрөгдсөн, үл хамаарах шалгууруудад хамруулах саналыг гарган судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т дотоод зуравсаар хүргүүлэн ажиллаж байна. /Тайлант хугацаанд 6 ААН-ын судалгааг хийж хүргүүлсэн/ 2. Бичиг баримтын шалгалтад зарцуулах хугацааг бууруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг зарим барааны бүлгээр дагнан бичиг баримтын шалгалт хийх боломжийг судлан нийт импортын гаалийн бүрдүүлэлтээс 8703, 8704-т хамаарах суудлын болон ачааны автомашин, зарим төрлийн чиргүүл, хүнд машин механизм гэж салган бичиг баримтын шалгалтыг хийх талаарх саналыг МТГ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн ба одоо ББГУБ нарыг ээлжээр ажлуулж байна. Мөн экспортын гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалтыг хийх гаалийн улсын байцаагчийн тусад нь хуваарьт оруулан ээлжээр ажлуулдаг болгосон нь ГУБ нар нэгдсэн байдлаар шийдвэр гаргах, үнэлгээний нэгдмэл байдал хангагдах бүрдүүлэлтэд зарцуулагдах цаг хугацааг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой ажил болсон. 3. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг МТГ-т хүргүүлэн ажиллаж байна. 2024.05.09-ны 62 тоот дотоод зурвасаар МТГ-т өдөр тутсын үйл ажиллагааг сайжруулах тулд КАЙС, СЕПС системд ойрын хугацаанд хийх шаардлагатай өөрчлөлтийн 20 саналыг хүргүүлсэн. Мөн нийт алба	2024.01.01-2024.06.05	96

				хөгжүүлэлтийн саналыг тухай бүрт нь гарган, МТТ-д хүргүүлсэн байна.	хаагч нар тоон гарын үсэг хэрэглэж эхэлсэнтэй холбоотойгоор БТКУС хариуцан ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчидад шаардагдах КАЙС програмд ажиллах эрхийн өөрчлөлтийн саналыг гарган төвийн удирдлагад танилцуулан ажилласан байна.		
2.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	1. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. 2. ГБМ-ний үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, улирал бүр /нийт 2 удаа/ засварт буцаалтад судалгаа, дүн шинжилгээ хийж, санал гарган БАҮХ-т хүргүүлсэн байна.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад тухай бүрт нь хяналт тавьж, зори тохиолдолд харьяа гаалийн газар, хороодын ГУАБ, ГУБ нараар дамжуулан заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна. 1. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах саналыг гарган ажиллалаа. Үүнд: Журмын төслийн Гурав. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зохицуулалт хэсгийн 3.8-д заагдсан Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэснийг Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй, бусдад дамжуулахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэж өөрчлөх. 2. Гаалийн бүрдүүлэлтийг алдаагүй, зөв хийхийн тулд ГБМ нартай тогтмол утсаар холбогдон заавар зөвлөгөө өгч, санал солилцон ажиллаж байна. Мөн ГБМ-т зарим анхаарах, мэдүүлэгт засвар оруулах шаардлага үүссэн үе бичиг баримтын гаалийн улсын байцаагч нараар дамжуулан Кайс, Сепс програмыг холбосон чатаар дамжуулан өгч ажиллаж байна.	2024.01.01-2024.06.05	95
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	1. Сургалт зохион байгуулах 2. Заавал шалгах, өндөр эрсдэлийн шалгуурууд болон хяналт шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг сар бүр 5-аас доошгүй ААН, иргэн, бараагаар хийж, ЭУХ-т хүргүүлсэн байна.	1. 2024.03.11-ны өдөр УБГГ-ын хурлын танхимд 2024.02.26-2024.03.01-ны хугацаанд Япон улсад зохион байгуулагдсан "Барааны ангилал, үнэ үнэлгээ, бүрдүүлэлтийн дараах шалгалт" сургалтын талаар ойлголт өгөх 2 цагийн сургалтыг бүрдүүлэлтийн цахим төвийн нийт алба хаагчдад хийж, мэдээ мэдээллээр хангаж ажилласан. 2. Гаалийн хяналт шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 6 ААН-ын судалгааг хийж, "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг боловсруулан төвийн даргад танилцуулж, Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024.04.12-ны 52, 2024.05.06-ны 58, 2024.05.30-ны 72 тоот дотоод зурвасуудад тусган ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлэн ажилласан байна. Цаашид хяналт шалгалтаас чөлөөлөх зорилгоор эрсдэлийн зөвшөөрөгдсөн шалгуурт оруулах ААН-ын саналаас гадна эрсдэлийн заавал шалгах шалгуурт оруулах ААН, иргэний судалгааг хийж холбогдох саналын хамтаар ЭУХ-т хүргүүлэн ажиллахаар төлөвлөн зарим ААН-ын судалгааг хийж эхлүүлээд байна.	2024.01.01-2024.06.05	98
4.	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Нэгжийн чиг үүргийн хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. 1. 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж эрх бүхий албан тушаалтанд баталгааны маягыг хүргүүлсэн. Мөн ГЕГ-ын даргын Б/133 тоот тушаалаар 2024.03.06-ны өдрөөс томилогдоод хуулийн хугацаанд нь шинээр томилогдсон албан тушаалтын мэдүүлгийг гаргасан. 2. Гаалийн харилцаанд оролцогч иргэн, ААН-ээс Бүрдүүлэлтийн цахим	2024.01.01-2024.06.05	95

төвийн 70001280 утсаар холбогдох явцад мэдээлэл өгөх автомат хариулагчийн үгийг бэлтгэн, ОНХХ-ийн ГУАБ Сайханзаяад хүргүүлсэн.

3. Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор "Монголын гааль" фэйсбүүк цахим хуудсаар 2024 оны 02-р сарын 26-ны өдөр Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга Э.Лхагвасүрэн нь "Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагааны талаар", 2024 оны 03-р сарын 05-ны өдөр ГУАБ Ө.Пунсалдулам "Импортын барааны гаалийн үнийн талаар", 2024 оны 02-р сарын 27-ны өдөр ГУБ Д.Ганбат "Гаалийн бүрдүүлэлтийн үйл явцын талаар" богино хэмжээний видео танилцуулга хийж олон нийтэд үйл ажиллагааг сурталчилсан ажлыг олон нийтийн сүлжээнд дэмжиж, түгээж ажилласан.

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

1.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна. 2. Судалгаа, дүн шинжилгээг хийж, санал дүгнэлтийг удирдлага болон холбогдох нэгжүүдэд хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан байна. 3. Гаалийн газар, хороодын удирдлагуудтай харилцан мэдээлэл, солилцож, хамтран ажилласан байна.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хүрээнд бүрэн алдаагүй хийхэд ГУБ нарт дэмжлэг үзүүлэн, заавар чиглэлийг хуулийн хүрээнд өгч, хамтран ажиллахын зэрэгцээ дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд: 1. Төвийн даргын баталсан "ГУАБ нарын хариуцсан бүлэг болон газар, хорооны хуваарь"-ийн дагуу БТКУС-ын 70, 84, 85-р бүлгүүдэд хяналт тавьж, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарт заавар, зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Мөн 7 хоног бүрийн мягмар гарагт гарч буй алдаа болон шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоол, тушаал, шийдвэрийн талаар танилцуулж, зарим бараагаар мэргэжлийг хүнийг урьж авчран сургалт зохион байгуулж, мэдээ мэлээллийг түгээж, мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Зарим тохиолдолд бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад бараануудын үнэлгээг дахин хянуулан ажиллалаа. Үүнд: БТКУС-ын 84-р бүлгийн бараа болох 2 төрлийн бутлуур, [redacted] дугаартай мэдүүлгийг бичиг баримтын шалгалт хийсэн төлөвөөс үнэлгээ буцааж, ҮМС-аар үнийг дахин хянуулан 9,507,598.26 төгрөгийн татварыг нэмж төлүүлсэн. [redacted] дугаартай мэдүүлгээр мэдүүлсэн сэнс, үнс холих, төхөөрөмж, экскаватор, экскаваторын шанаганы үнийг бичиг баримтын шалгалт хийсэн төлөвөөс үнэлгээ буцааж, дахин хянуулан нийт 61,489,283 төгрөгийн гаалийн болон бусад татварыг нэмж төлүүлсэн. НИЙТ-70,996,881 төг. 2. БТКУС-ын 68 дугаар бүлэгт хамаарах барааны гаалийн нэгж үнийн судалгааг 2024.03.01-2024.03.31 тасалбар болгон өмнөх оны мөн үетэй харьцуулан хийж, удирдлагад танилцуулан ГЕГ-ын холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн төвийн даргын баталсан "ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарь" дагуу дараах судалгаа, дүн шинжилгээг ГУБ нартай хамтран хийлээ. Үүнд: - Орлогын дүн шинжилгээг 2024 оны 1-р улирал, 4 болон 5-р сараар 3 удаа хийж, төвийн даргад хянуулан, мэдээллээр хангасан. - БТКУС-ийн 84-р бүлэг хариуцсан ГУБ 237, 652, 1430, 1438 нарт чиглэл	2024.01.01-2024.06.05	98
----	--	-------------------------	---	---	---	-----------------------	----

					өгч тухай бүлэгт хамаарах зарим бараагаар гарын авлага гаргахаар ажиллаж байна. - БТКУС-ийн 8429 зүйлд ангилагдах зарим төрлийн экскаваторын баримжаа үнийн судалгааг ГУБ 1438-тай хамтран хийж байна. 3. ЗҮГГ-ын дарга, холбоо баригч ГУБ нартай холбоотой байж, хамтарсан манифестын лавлагааг хурдан шуурхай гаргуулан хамтран ажиллаж байна. Үнийн дүн өндөртэй авахуулсан лавлагаанаас дурдвал: [REDACTED] [REDACTED] ХХК /ГХО/-ны 4 мэдүүлгээр /6 автомашин/ мэдүүлсэн бараанд (34560,32 ам.доллараар мэдүүлэн 18,113,115.3 төгрөгийн гаалийн болон бусад татвар төлөхөөр мэдүүлсэн байсанд) эрсдэл тооцон ЗҮГГ-ын даргад мэдэгдэн, холбоо баригчаар дамжуулан хамтарсан манифестын лавлагаа авч 202,488,669.3 төгрөгийн гаалийн болон бусад татварыг төлүүлсэн. /Зөрүү нь 184.375,553.8 төгрөг/		
2.	Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил	Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн	-	2. Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. 4. Гааль зөвшөөрөв төлөвөөс засварт буцааж мэдүүлэгт засвар оруулсан байдлыг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар бууруулна.	[REDACTED] ХХК-ны мэдүүлсэн барааны гаалийн нэгж үнэд эрсдэл тооцон хамтарсан манифесыг лавлагаа авахуулсан. Өндөр үнийн дүнтэй ирсэн хамтарсан манифестын үнийн дүнгээр баримжаалан гаалийн үнийг шинээр тогтоосон ба ААН-ын зөрчлийн тухай хуулийн 11.21.12-т заасны дагуу арга хэмжээг авахуулан 2,000,000 төгрөгөөр торгосон.	2024.01.01-2024.06.05	95
3.	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.	Бичиг баримтын шалгалтын явцад гаалийн бүрдүүлэлтийн горимын шаардлагыг мөрдлөгө болгон, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн 2024.05.01-ны өдрийн ЗГ-ын 180 дугаар тогтоолоор "Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн грилын жагсаалт" батлагдсан тул тухайн жагсаалтад хамрагдах 11 БТКУС-ын кодын гаалийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн 2024.05.01-ны өдрийн ЗГ-ын 188 дугаар "тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор "Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай" тогтоолыг уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	2024.01.01-2024.06.05	90
4.	Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна. 2. Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн	Тайлант хугацаанд барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх тодорхойлох чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд: 1. БТКУС-ын 8703 зүйлд хамаарах gruis маркын суудлын автомашиныг сонгон бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ-ын кайс програмд альваа оролцоогүйгээр туршилтаар "өөрөө үнэлэгдэх" ажлыг хийж хэрэгжүүлэхээр эхлүүлээд байна. Дээрх ажлын хүрээнд БЦТ-аас	2024.01.01-2024.06.05	96

				орлогын, горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр хийж, удирдлагыг мэдээллээр ханган, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сажруулсан байна. 3. Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна.	судалгаа хийж, саналын хамтаар МТГ хүргүүлсэн ба МТГ-ын ГУАБ Мөнхзүл, ГУБ Хорлоо, Энхсайхан нар БЦТ-д ирж хамтарсан хурал хийж, КАЙС програмд холбох талбарууд, хийгдэх өөрчлөлт, гарч болох хүндрэл, шийдвэрлэх арга замыг эхний удаад хэлэлцсэн ба МТГ-т кайс програмын холбогдох өөрчлөлтийг хийж байна. Мөн эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлэх ажлын хүрээнд дараах барааны үнийн хяналтыг багийн системээр хэрэгжүүлсэн. ✓ Трактор ✓ Автобус ✓ Суудлын автомашин ✓ Ачааны автомашин ✓ Тусгай зориулалтын автомашин ✓ Мотоцикл ✓ Чиргүүл ✓ 84.26, 84.27, 84.29, 84.30, 84.28 (Машин, механизм) Үүнийн үр дүнд бүрдүүлэлтийн цаг хугацаа буурсан, нэгдмэл шийдвэр гарна, машин, тоног төхөөрөмжийн үнийн хяналт сайжирсан, ГУБ нар тухайн мэргэшиж барааны талаарх мэдээлэл авах боломж бүрдээд байна. 2. БТКУС-ын 68 дугаар бүлэгт хамаарах барааны гаалийн нэгж үнийн судалгааг 2024.03.01-2024.03.31 тасалбар болгон өмнөх оны мөн үетэй харьцуулан хийж, удирдлагад танилцуулан ГЕГ-ын холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн төвийн даргын баталсан "ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарь" дагуу дараах судалгаа, дүн шинжилгээг ГУБ нартай хамтран хийлээ. Үүнд: - Орлогын дүн шинжилгээг 2024 оны 1-р улирал, 4 болон 5-р сараар 3 удаа хийж, төвийн даргад хянуулан, мэдээллээр хангасан. 3. 2024 оны 5 дугаар сараас эхлэн БЦТ-ийн ГУАБ нарт барааны лавлах санг баяжуулах эрхийг Кайс програмд нээж өгсөн. Дээрх ажлын хүрээнд иргэн, ААН болон ГБМ нараас утсаар ирүүлсэн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч, марк, моделийг тухай бүрт нь хурдан шуурхай Кайс програм бүртгэн, гаалийн бүрдүүлэлтийг тасралтгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн өдөр бүрийн орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, цэвэр жин, /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн шинжилгээ хийж, ТОГ-т хүргүүлэн ажиллаж байна.		
Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1.	Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Бүрдүүлэлтийн цахим төвд ирсэн өргөдөл, гомдол, маргаануудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүрэн шийдвэрлэн ажиллаж байна. Үүнд: 1.БЦТ-ийн ГУАБ нар 7 хоногоор ээлжлэн БТКУС хариуцан гомдол мэдээллийг шийдвэрлэн ажиллаж байсан ба зохион байгуулалтын өөрчлөлт оруулан 1 сарын хугацаагаар хуваарь гарган хуваарийн дагуу	2024.01.01-2024.06.05	97

				2. Шийдвэрийн мэдээллийг кайс системийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байна.	ажилдаг болсон. Дээрх хуваарийн дагуу 2024 оны 6-р сард БТКУС хариуцан өргөдөл, гомдол, үнэлгээний маргааныг холбогдох хууль тогтоомж, журам зааврын хүрээнд бүрэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 2024 оны 1-р сараас 5 сар хүртлэх хугацаанд өргөдөл, гомдлыг хариуцан ажиллахдаа tsakhimgaali@customs.gov.mn цахим хаягаар ирүүлсэн 88 гомдол, 135 хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох албан тушаалтануудтай зөвлөлдөн, хугацаанд нь хариуг нь өгч, бүрэн шийдвэрлэн ажилласан байна. 2. Шийдвэрийн мэдээллийг СЕРП програмын дуудлагын төв цэсэнд тухай бүрт нь бүрэн алдаагүй оруулан бүртгэлжүүлэн ажилласан байна.		
2.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	1. Төвийн даргын баталсан “ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарь”-ийн дагуу дараах төлөвлөгөөнүүдийг холбогдох баримт бичгүүдийн хүрээнд боловсруулан ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн. - Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, ажил хариуцсан ГУАБ нараас санал авч төлөвлөгөөний зарим ажилд засвар өөрчлөлт оруулан төвийн даргаар хянуулан, батлуулахаар ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн. - Төвийн даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулахаар ГЕГ-т ЗУГ-т хүргүүлсэн. - Төвийн нийт ГУАБ, ГУБ нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулан, хяналт тавьж, ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн. 2. ГЕГ-ын БАҮХ-тэй хамтран улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн барааны ангиллын кодыг тодорхойлон ажиллаж байна.	2024.01.01-2024.06.05	96
3.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна.	Гаалийн бүрдүүлэлт, холбогдох хууль тогтоомж, журам зааврыг боловсронгуй болгон ажлын хүрээнд дараах саналыг гарган ажилласан байна. Үүнд: 1.“Гаалийн байгууллагаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө”-ний төсөлд 2. “2024 онд олон нийтэд сурталчлах төлөвлөгөө” боловсруулан, саналыг 3.ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах саналыг гарган ажиллалаа. Үүнд: Журмын төслийн Гурав. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зохицуулалт хэсгийн 3.8-д заагдсан Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэснийг Мэдүүлэгчийн нууцыг	2024.01.01-2024.06.05	92

					задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй, бусдад дамжуулахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэж өөрчлөх.		
4.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бүрдүүлэлтийн цахим төвийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна.	Бүрдүүлэлтийн цахим төвийн гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд гаалийн хяналт шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 6 ААН-ын судалгааг хийж, “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг боловсруулан төвийн даргад танилцуулж, Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024.04.12-ны 52, 2024.05.06-ны 58, 2024.05.30-ны 72 тоот дотоод зурвасуудад тусган ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлэн ажилласан байна. Цаашид хяналт шалгалтаас чөлөөлөх зорилгоор эрсдэлийн зөвшөөрөгдсөн шалгуурт оруулах ААН-ын саналаас гадна эрсдэлийн заавал шалгах шалгуурт оруулах ААН, иргэний судалгааг хийж холбогдох саналын хамтаар ЭУХ-т хүргүүлэн ажиллахаар төлөвлөн зарим ААН-ын судалгааг хийж эхлүүлээд байна.	2024.01.01-2024.06.05	98
5.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Тайлант хугацаанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлуудыг хугацаанд нь бүрэн хийж хэрэгжүүлэн ажиллалаа. 1. Нийт алба хаагчдыг үүрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах, үүрэг даалгаврын биелэлтийг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, хариуцлага хяналтыг нэмэгдүүлэхээр ажлын хуваариудыг хийж, ГУАБ нараас санал авч нэгтгэн, удирдлагад хянуулан батлуулсан. Үүнд: • ГУАБ нарын хариуцсан ажлын хуваарийг /БТКУС, газар хороогоор хуваарилсан/, • ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарийг /байнга хариуцан ажиллах 20 ажил үүргийг нийт алба хаагчдад хуваарилсан/, 2.Төвийн даргаас үүрэг болгосоны дагуу “Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт”-д заагдсаны дагуу “Бүрдүүлэлтийн цахим төвийн” 4 АТТ, Гаалийн газар хорооны бүрдүүлэлтийн албаны 3 АТТ нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, харьцуулалт хийж, хянуулахаар ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн. Мөн ГЕГ-ын БАҮХ-ийн албан тушаалын тодорхойлолтуудыг харьцуулалтыг хийж, хугацаанд нь ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт”-ад заагдсаны дагуу “Бүрдүүлэлтийн цахим төвийн” 4 АТТ, Гаалийн газар хорооны бүрдүүлэлтийн албаны 3 АТТ, ГЕГ-ын БАҮХ-ийн албан тушаалын тодорхойлолтуудыг эцсийн байдлаарх тулгаж шалгаж ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ШХТ, ЭУХ, ХБГ-ын сүүлийн байдлаарх албан тушаалын тодорхойлолтын төслүүдийг ШХТ-ийн дарга Ц.Хатанболд, ЭУХ-ийн дарга Д.Цэндсүрэн, ХБГ-ын ГУАБ Д.Ариунцэцэг нарт танилцуулан гарын үсгээр баталгаажуулан ажлын хэсэгт хүргүүлсэн. 3. Албан бичгийн едок програмаар хуваарилагдан ирсэн 42 хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.	2024.01.01-2024.06.05	98

					5. Үйл ажиллагаатай холбоотойгоор ГЕГ-ын холбогдох нэгжүүдээс болон удирдлагаас холбогдох хууль тогтоомжийн хүрээнд өгсөн бусад үүрэг даалгаварыг тухай бүрт нь хугацаанд нь бүрэн биелүүлэн ажиллалаа.		
6.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	1.Алба хаагчдын ажлын цагийг бүрэн бүртгэж, хяналт тавьсан байна. 2. Ажлын цаг ашиглалт 90 хувиас доошгүй байна.	1. Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй ба ажлын цаг ашиглалт 100 хувь ажилласан. 2. Төвийн даргын баталсан хуваарийн дагуу 2024 оны 6-р сард БТКУС хариуцан ажиллахын зэрэгцээ нийт алба хаагчдын ажлын цаг ашиглалт хяналт тавин, нийт алба хаагчдын илүү цаг болон амралтын өдрөөр ажиллах, ажлын өдрөөр амрах, ажиллах хуваарийг хийж, бүртгэл хөтлөн, өдөр тутмын ирцийн мэдээг өглөө бүр гарган төвийн удирдлагад, 6-р сарын эхний хагас хугацааны цагийн бүртгэлийн гарган ГЕГ-ийн СХОХ-т тус тус хүргүүлэн ажиллаж байна.	2024.01.01-2024.06.05	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Нийт алба хаагчдыг үүрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах, үүрэг даалгаврын биелэлтийг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, хариуцлага хяналтыг нэмэгдүүлэхээр ажлын хуваарийг хийж төвийн даргад танилцуулан, батлуулж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	Төвийн даргаас үүрэг болгосоны дагуу ГУАБ, ГУБ нарын давхар хариуцан ажиллах ажил үүргийн хуваарийн төслийг боловсруулан, ГУАБ нараас санал авч нэгтгэн, удирдлагад хянуулан батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: - ГУАБ нарын хариуцсан ажлын хуваарийг улирлаар баталсан. /БТКУС, газар хороогоор хуваарилсан/, - ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарийг мөн улирлаар төвийн дарга баталсан ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. /байнга хариуцан ажиллах 20 ажил үүргийг нийт алба хаагчдад хуваарилсан/,	2024.01.01-2024.06.05	100
2.	"Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт"-д заагдсаны дагуу хуваарилагдсан АТТ төслийг боловсруулан ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн байх.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	Төвийн даргаас үүрэг болгосоны дагуу "Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт"-д заагдсаны дагуу "Бүрдүүлэлтийн цахим төвийн" 4 АТТ, Гаалийн газар хорооны бүрдүүлэлтийн албаны 3 АТТ нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, харьцуулалт хийж, хянуулахаар ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн. Мөн ГЕГ-ын БАҮХ-ийн албан тушаалын тодорхойлолтуудыг харьцуулалтыг хийж, хугацаанд нь ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын	2024.01.01-2024.06.05	95

					төлөвлөгөөний хавсралт"-ад заагдсаны дагуу "Бүрдүүлэлтийн цахим төвийн" 4 АТТ, Гаалийн газар хорооны бүрдүүлэлтийн албаны 3 АТТ, ГЕГ-ын БАҮХ-ийн албан тушаалын тодорхойлолтуудыг эцсийн байдлаарх тулгаж шалгаж ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ШХТ, ЭУХ, ХБГ-ын сүүлийн байдлаарх албан тушаалын тодорхойлолтын төслүүдийг ШХТ-ийн дарга Ц.Хатанболд, ЭУХ-ийн дарга Д.Цэндсүрэн, ХБГ-ын ГУАБ Д.Ариунцэцэг нарт танилцуулан гарын үсгээр баталгаажуулан ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	1.2024.02.26-2024.03.01-ны өдрүүдэд Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан "Барааны ангилал, үнэ үнэлгээ, бүрдүүлэлтийн дараах шалгалт" сэдэвт сургалтад хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. 2.2024.03.11-ны өдөр УБГГ-ын хурлын танхимд 2024.02.26-2024.03.01-ны хугацаанд Япон улсад зохион байгуулагдсан "Барааны ангилал, үнэ үнэлгээ, бүрдүүлэлтийн дараах шалгалт" сургалтын талаар ойлголт өгөх 2 цагийн сургалтыг бүрдүүлэлтийн цахим төвийн нийт алба хаагчдад хийж, мэдээ мэдээллээр хангаж ажилласан. 3. Бүрдүүлэлтийн цахим төвийн алба хаагчид 7 хоног бүрийн Мягмар гарагт өглөө 8 цагаас мэдээ, мэдээллийн цагийг уламжлал тогтмол зохион байгуулж байна. Дээрх хугацаанд зохион байгуулагдсан гадна байгуулагаас мэргэжилтэн урьж авчирсан сургалтаас дурдвал: - ГЕГ-ын ЭУХ-ээс "Гаалийн хяналтын стратеги", - Эм, эмнэлэгийн зохицуулах газартай хамтран биологийн идвэخت бүтээгдэхүүний талаарх сургалт - Шилэн хийц компанитай хамтран ганжуулсан болон тунгалаг шилний ялгаа, үнэ үнэлгээний талаарх гэх мэт зохион байгуулагдсан сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажилласан, - Зам тээвэр, хөгжлийн яамны холбогдох албан тушаалтануудтай хамтран "Чиргүүл, чирэгч толгойн стандарт",	2024.01.01-2024.06.05	100
2.	Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Хууль эрх зүйн мэдлэг сайжирч,	Үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гарсан холбогдох хууль, тогтоол, журам, заавартай танилцан үйл ажиллагаандаа	2024.01.01-2024.06.05	100

шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах		өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	мөрдөн ажиллаж байна. Үүнд: - 2024.05.01-ны өдрийн ЗГ-ын 180 дугаар тогтоолоор "Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн грилын жагсаалт" батлагдсан тул тухайн жагсаалтад хамрагдах 11 БТКУС-ын кодтой танилцан, уншиж судалсан. - 2024.05.01-ны өдрийн ЗГ-ын 188 дугаар "тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор "Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай тогтоолыг уншиж судлаад байна.		
---	--	---	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
(Албан тушаал)

Г.СОНОМЦЭВЭЭН / 
(Нэр, гарын үсэг)

2024. 06. 10
(Огноо)

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ГАНБОЛДЫН СОНОМЦЭВЭЭНИЙ
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалахыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	53.4	9	62.4	
2.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа	53.4	9	62.4	
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	53.4	9	62.4	
4.	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	53.4	9	62.4	
Зорилт 2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал	53.4	9	62.4	
2.	Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил	53.4	9	62.4	
3.	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт	53.4	9	62.4	
4.	Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил	53.4	9	62.4	
Зорилт 4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал	53.4	9	62.4	
2.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	53.4	9	62.4	
3.	Үүрэг даалгаврын биелэлт	53.4	9	62.4	
4.	Ажлын цаг ашиглалт	53.4	9	62.4	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Бүрдүүлэлтийн цахим төвийн ажлын				

байрны засварыг хариуцсан ажлын хэсэгт орж санаачлагатай ажиллах	53.4	9	62.4
Дундаж оноо:	53.4	9	62.4

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх	86.4	13	
2.	Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах	86.4	13	
	Дундаж оноо	86.4	13	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	4	
2.	Дүн шинжилгээ хийх	4	
3.	Асуудал шийдвэрлэх	4	
4.	Хариуцлагатай байдал	4	
5.	Ажлын цаг ашиглалт	4	
	Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	4	
	Дундаж оноо	4	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
	Дундаж оноо	8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг баалаагаар (агаа хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 62.4
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 4
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргаачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)

Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	90.7
--	-------------

Үнэлгээ өгсөн:

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга



/Э.Лхагвасүрэн/
(албан хаагчийн нэр)
 2024.06.12 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Гаалийн улсын ахлах байцаагч
(албан тушаал)



/Л.Сономцэвээн/
(албан хаагчийн нэр)
 2024.06.13 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)



/Л.Энхтайван/
(албан хаагчийн нэр)
 2024.07.26 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)



/Ж.Баясгалан/
(албан хаагчийн нэр)
 2024.07.26 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

ГЕГ-ын дарга
(албан тушаал)



Төсвийн шууд захирагч
(гарын үсэг)
 /Р.Отгонжаргал/
(албан хаагчийн нэр)
 2024.07.26 (огноо)